

2025 он 08 сар 08 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

**Өрийн хэрэгсэл бүртгэлээс хасуулахыг зөвшөөрөх тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2, 41.3, 41.5, 76 дугаар зүйлийн 76.1.5 дахь заалтыг тус тус удирдлага болгон “Говь” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Говь ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 29-ний №16 тоот тогтоолын дагуу эргэлтийн хөрөнгийн санхүүжилт, хөрөнгө оруулалт болон дахин санхүүжилт хийх зорилгоор 16,800,000 /арван зургаан сая найман зуун мянга/ ам.долларын үнийн дүн бүхий үнэт цаас /өрийн хэрэгсэл/-ийг “Биржийн бус зах зээл”-д гаргахаар шийдвэрлэснийг дурдсугай.
2. Дээрх шийдвэрийн дагуу “Говь бонд 2” өрийн хэрэгслийг 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны БХ24/57 дугаар тогтослоор бүртгэж, “Говь бонд 2” нь Говь 2.1, Говь 2.2, Говь 2.3 гэсэн гурван транчаар арилжаалж үндсэн төлбөр болон транчийн хүү бүрэн төлөгдөж дууссаныг дурдсугай.
3. Геополитикийн тодорхойгүй байдал, макро эдийн засгийн тогтворгүй орчин, ам.долларын ханшийн хэлбэлзэл зэргээс шалтгаалан “Говь бонд 2” өрийн хэрэгслийг цаашид зах зээл дээр арилжаалах боломжгүй болсон тул энэхүү өрийн хэрэгслийг “Биржийн бус зах зээл”-ийн бүртгэлээс хасуулахыг Санхүү хариуцсан захирал /Б.Хангалан/-д зөвшөөрсүгэй.
4. Өрийн хэрэгслийг бүртгэлээс хасуулахтай холбоотой бүхий л баримт бичигт гарын үсэг зурж баталгаажуулах бүрэн эрхийг Санхүү хариуцсан захирал /Б.Хангалан/-д олгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:		Ц.БААТАРСАЙХАН
ТУЗ-ИЙН ГИШҮҮД:		Б.АМАРСАЙХАН
		Д.ГЭРЭЛМАА
		А.ЖАРГАЛМАА
		Б.ОРГИЛ
		Ц.ОРГИЛБОЛД
		Д.ХУЛАН
		Д.ХҮРЭЛБААТАР
		Б.ЦЭЭНЯМ



2025 он 08 сар 08 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

**Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох тухай**

Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь хэсгийг удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Говь ХК нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар компанийн хэлбэрийг өөрчлөх асуудал хэлэлцэн шийдвэрлэхээр төлөвлөж буйтай холбоотой бэлтгэлийг хангах зорилгоор компанийн 2025 оны хагас жилийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагаар “Релаэнс Секюритиз Аудит” ХХК-ийг сонгосугай.
2. “Релаэнс Секюритиз Аудит” ХХК-тай байгуулах гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг Бүртгэлийн газрын захирал /Д.Содгэрэл/-д олгосугай.
3. Хөндлөнгийн аудитын дүгнэлт, захидлыг хүлээн авч, Эрсдэл аудитын хороо болон Төлөөлөн Удирдах Зөвлөлд танилцуулахыг Бүртгэлийн газрын захирал /Д.Содгэрэл/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

ТУЗ-ИЙН ГИШҮҮД



*[Handwritten signature]*

Ц.БААТАРСАЙХАН

Б.АМАРСАЙХАН

Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

Б.ОРГИЛ

Ц.ОРГИЛБОЛД

Д.ХУЛАН

Д.ХҮРЭЛБААТАР

Б.ЦЭЭНЯМ

2025 он 08 сар 08 өдөр

Дугаар 36

Улаанбаатар хот

**Хувьцааны үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээ  
байгуулахыг зөвшөөрөх тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2, 55.6, 76 дугаар зүйлийн 76.1.6 дахь заалтыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Говь ХК нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар компанийн хэлбэрийг өөрчлөх асуудал хэлэлцэн шийдвэрлэхээр төлөвлөж буйтай холбоотой Компанийн тухай хуулийн 53 болон 54 дүгээр зүйлд заасан “Хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах зорилгоор нэгж хувьцааны үнэлгээний ажил гүйцэтгэх компаниар “Арвижих Эстимэйт Үнэлгээ” ХХК-ийг сонгосугай.
2. “Арвижих Эстимэйт Үнэлгээ” ХХК-тай байгуулах гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг Санхүү хариуцсан захирал /Б.Хангалан/-д олгосугай.
3. Хувьцааны үнэлгээний тайланг хүлээн авч, Төлөөлөн Удирдах Зөвлөлд танилцуулахыг Санхүү хариуцсан захирал /Б.Хангалан/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:



*[Handwritten signature]*

Ц.БААТАРСАЙХАН

*[Handwritten signature]*

Б.АМАРСАЙХАН

*[Handwritten signature]*

Д.ГЭРЭЛМАА

*[Handwritten signature]*

А.ЖАРГАЛМАА

*[Handwritten signature]*

Б.ОРГИЛ

*[Handwritten signature]*

Ц.ОРГИЛБОЛД

*[Handwritten signature]*

Д.ХУЛАН

*[Handwritten signature]*

Д.ХҮРЭЛБААТАР

Б.ЦЭЭНЯМ